

Зилахи Пээтэр – Анаашаас Ямаа Хүртэлх Сүүлчийн Ном

Анаашаас ямаа хүртэл гэдэг нэртэй нэг зурагт ном буюу хүүхдийн лэксикон байв. Бид нар уншиж сураагүй байхдаа түүнээс уншиж сурсан билээ. Би хэдийн уншаад сурчихсан хүүхэд байв, тэгээд ч сурах л ёстой байлаа, сурахгүй юм бол сургуулийн хэрэг гэж юу байхав. Анаашаас ямаа хүртэл гэсэн нэртэй энэхүү ном бидний өмнө, ертөнцийг нэн ойлгомжтой байдлаар цагаан толгойн үсгийн дарааллаар нээн үзүүлсэн юм. Бүх юм өөрийн гэсэн утга санаа, өөрийн гэсэн байр, эсвэл билэгдэлтэй буюу өдөр тутмынх гэх жишээтэй, бид нар түүнээс, нар зүүнээс мандах, зүрх зүүн талд байрладаг буюу октябрийн хувьсгал арван нэгэн сард болсон, цонхоор гэрэл нэвтрэн орж ирдэг – хэрвээ хаалттай байсан ч гэсэн. "Анаашаас ямаа хүртэл"–д долоон толгойтой луу, лусын дагина, чөтгөр, ханхүү гэх мэт зүйл дүүрэн байдаг боловч тэдний тухай бичихдээ эдгээр нь үл оршдог юм гэсэн тайлбартай. Би лав дөрвөн төрлийн луу, гурван ханхүүгийн тухай бичсэн байдгийг санаж байна, тэдгээр нь үл орших бөлгөө. Анааш ба ямаа нь мөрийн хооронд үгийг үе члэн уншиж сурахад сургадаг. Тэлэвизийн үлгэрийн дараах бамбарууш шиг унтахаар хэвтэх нь өөрөөсөө ойлгогдох ба түүнээс юм асууя гэж тухайн цагтаа хэний ч санаанд орсонгүй. Анааш ба ямаа нэрт ном ном л бол ном. Энэ ном бол миний хүүхэд нас, хувцас өмсөх өрөө, биеийн тамирын хичээл, үргэлжийн өсөлт, нэг сайхан насны өмнөх нас, зөөлөн диктатур, миний гэрийн даалгавар, миний гэм зэмгүй үе буюу нэгэн үеийнхэн минь юм. Анааш ба ямаа бол нэг ном билээ, би өөрөө түүний нэг дүр юм. Хорин жилийн дараа хэн нэг нь надаас ийн асуухад нь, би эхний болоод сүүлчийн үг альфа ба омега нь анааш ба ямаа гэдэг үг болохыг мэдсэн билээ. Миний эх хэл мажаараар цонх гэдэг үг бас ПаП үсгээр эхэлдэг бөгөөд, *a* –гаар эхэлсэн цонх гэсэн үг энэ номонд хамгийн эхний үг, цонхоор гэрэл орж ирнэ, анааш бол төгсгөлгүй өндөр ба сюрреализм, дүрэлзэх анаашууд, хэзээ ч үхэхгүй! Нэг лэксикон түүн дотор, үлдсэн юм бүхэн бий.

Анааш ба ямаа Парист бас байдаг юм билээ, би нэг ил захидлаас харсан юм, тэд нар түүнийгээ *эйфэлцамхаг* гэж нэрлэдэг. Брүннэр Жуфи гэдэг охин илгээсэн бөгөөд, тэр эцэг эхтэйгээ Францад гарчихсан охин, тэр одоо франц цагаан толгойтой номноос сурч байгаа. Эйфэлийн цамхаганд урт хүзүү, дөрвөн хөл, асар олон цонх бий. Тэр нь нийлээд цонх ба анааш болно, нэр нь ч зүгээр сонссогдож байгаа биз, шавдуулалт ба амлалт, *би бяцхан боловч–хожим өсөж томроод* цэцэн мэргэн рэторикаг давж гараад, гэнэтийн үсрэлт нь доороос харах байдлаас бүрмөсөн тасрах амлалтаар дурыг татаад, түүнийг дунд хирд явах хурдан лифт тэхникийн асуудлыг доош нь буулгана. Брүннэр Жуфи ч бас түүнийг нэг анааш шиг гэж харсан байв, зөвхөн цонхгүй буюу дотор нь хурдан лифтгүйгээр харсан аж. Хурдан лифт хүзүүнд минь байв, татдаг трубны иш шиг хөлөөрөө шалан дээр явахыг зөвшөөрөх үед гаатай баллуурыг үнэртэв би. Бүх шөнөжин балартсан ухаанаар үечлэн уншив, үсгүүд яг л муурны нүд гудамд өөдөөсөө гүйх адил байлаа. Жуфи дараа өдөр нь бүрмөсөн орхисон юм мажаар орныг. Ангийн багш мэдэгдэхдээ, тэд нар гэнэт л яваад өгчихсөн гэв. Гэнэтийн эмнэгэлтэй байдлаар ерөнхий нарийн бичгийн дарга нар яваад өгдөг шиг явлаа гээд хэлж болох л байсан. Миний сэтгэлд гаатай баллуур арилгахын аргагүй ул мөрөө үлдээсэн юм. Зөвхөн хожим нь мэдсэн билээ бид нар, тэднийхэн зуны амралтаараа амрахаар яваагүйг нь, тэр өөрийнхөө оронд эйфэлийн цамхагийг илгээсэн байлаа, тэр ном нь яг л анааш ба ямаатай адилхан ном байв, гэхдээ дор хаяад л мөрүүдийн хооронд уншиж чадах хүнд бол ямар нэг утгатай л байсан буй. Сайхан үг, яг л хөлдүү юм шиг. Миний санаж буй хүүхэд насны минь анхны дурсамж гэвэл: нам гүм амрах цэцэрлэгт дөрвөн хөллөөд мөлхөж байв. Хөшиг унжуулсан танхим дахь цагаан бүтээлгэнд сар тусна. Сар байж болохгүй шүү дээ, орой үдэш бид нар цэцэрлэг дээр байдаггүй байсан юм чинь. Дөрвөн хөллөөд орнуудын хооронд мөлхөхдөө, юунаас айдаг байсан гэвэл бусдууд маань сэрчихвэл би ч сэрчихнэ гэдгээс. Би ганцаараа, бараг л нэг олсон хүүхэд, шарчигнах шалан дээр тэнцвэрээ олоход, өвдөгөнд минь талхны үрдэс өрөмдөн орно. Би жижиг болохоор хэн ч үл харна, том танхимд урагшаа гулсах бөгөөд тэр нь хэдэн цаг явсан мэт. Цагаан хэрэглэлийн хооронд унжих хөл, гаруудыг эвтэйхэн сүлжиж явав. Лусын дагинасууд үхлүүт хэвтэгцээнэ. Хонин үүлс зохицсон журмаараа хөвөөд, пэдофилийн диваажин, хурууны зөөлөн өндөг, хонхорхой, буржгар үс. Тэгтэл! Орон доор хэн нэг нь өөдөөс ирж харагдав, бидний толгой мөргөлдөв, цагаан даавуунаас болоод нүүрийг нь харж чадсангүй. Хүзүүн дээр аахилна, амьсгал нь хав халуун. Асрах багш нар ирэх ба тэд цагаан халаад, цагаан оймс, цагаан улавчтай аж, орон доороо бид нам болов, жижиг гараараа жижиг гарыг барилаа, алга нь хөлрөв. Яа,яа!

Миний явдаг байсан сургууль Бүргэд–уулан дээр байх бөгөөд түүхт барилга байв, сургалт явуулдаг байгууллага болохынхоо өмнө гэлэнмаа нарын хаалттай хашаа байжээ. Гэрманууд дайран орж ирэхэд бүжгийн танхимд цэргийн төв штаб байрлаж байсан гэх ба энд Будапэштийн цэргийн удирдагчийг баривчилсан гэдэг. Бүжгийн танхимд биеийн тамирын хичээл ордог байсан бөгөөд, түүхт ханын хооронд бид нар тойрон тойрон гүйдэг байлаа, эх орноо мэдэх хомсхон толгойтонууд. Соёо сахалт ах хэлэхдээ, мажаарууд ард түмнүүдийн их замаар ирцгээсэн юм гэх нь сайхан сонсогддог байв. Чөмөгтэй ясаар их талд дайгдах ба түүн дээр нь шаантаг үсгээр ийн бичээстэй:

Мажаар орон, гэвч үүнийг хэнч уншиж үл чадна. Багшийнхаар бол Номхон далайгаас Дунай нам дор газар хүртэл, нэгээхэн зэлүүд хээр тал буй гэх ба тэр нь багцаагаар Амар мөрөн Дунай мөрний хооронд гэнэ. Нэг захад нь мажаарууд, нөгөө захад нь Гулагууд бий бөгөөд ингэж харьцаар ирэв. Хоёр гараар алагдуулсан юм, учир нь дайрахгүй гэж, энэ нь алтан дундаж гэгч байв. Би үгүйдээ олс өөд авирья эсвэл хоёр тойрог гүйе гэж хэлэв би, тэр хэлэхдээ, гараас надаас татаж авна гэлээ, жингээрээ над дээр улам дарав, тэр зөвхөн *шудрага мажаар хүнийг* сийлэхийг хүсчээ. Би ямар нэг юм болохгүй байна гэдгийг мэдэж байсан юм, учир нь тийм гэхэд, бидний хэл бол хамгийн том эрдэнэ, тэр үлдэн хоцорч чадаж, тэгтэл намайг амаа тат гэж ятгахыг хүссэн тэд, эх орноо танинмэдэхүйг анатомитой, эх оронч байдлыг хэлзүйтэй, эв санааны нэгдэлийг бол сийлбэртэй нэг болгон угаасан тэд. Үгчилбэл мажаарууд мянган жилийн тэртээ ирцгээсэн, өнөөдөр ч бас ирцгээнэ, хэрэв үхээгүй л бол. Хаанаас хаашаа гэдгийг нь хэн ч үл мэднэ.

Хүүхэд насны тухай бичсэн романы хэсгээс

© Péter Zilahy | <http://www.zilahy.net>

